

## ЧИНГИС ХААНЫ ДУНДАД АЗИ РУУ ХИЙСЭН АЯН ДАЙНД ЕЛЮЙ ЧУЦАЙ ОРОЛЦСОН НЬ /1219-1227/

*Н.Төмөр\**

Чингис хаан Елюй Чуцайг 1218 онд Хэрлэн мөрний хөвөөн дэх ордондоо хүлээн авч уулзсаны дараа, түүнийг дэргэдээ шадар болгон байлгахаар шийджээ. Елюй Чуцай Чингис хааны зөвлөгч, төлөгч, бичээчээр ажиллаж байгаад нэг жилийн дараа 1219 оноос Чингис хааны баруун зүг рүү буюу Дундад Азийн орнуудад явуулсан аян дайнд биеэр оролцож, Дундад Азид 10 орчим жил ажиллаж амьдарч байлаа. Энэ талаар Елюй Чуцай “Өрнө этгээд зорчсон тэмдэглэл” зохиолдоо тодорхой дурдан бичжээ.<sup>1</sup>

Чингис хаан Алтан улсын эсрэг байлдаж, хэд хэдэн тулааны дараа Алтан улсын нутагт гүн нэвтэрч, улмаар 1215 онд нийслэл хот Чжунду /одоогийн Бээжин хот/-г эзлэн авч, асар их хэмжээний олз омогтой буцаж ирсний дараа зэвсгийн үзүүрийг баруун зүг, Дундад Азийн орнуудын эсрэг хандуулжээ. Чингис хааны цэрэг хамгийн түрүүнд Хар хятаны Баруун Ляо улсыг довтлон, 1218 онд Зэв жанжинаар удирдуулсан хоёр түмэн цэрэг Баруун Ляо улсыг хялбархан эзлэн авчээ.<sup>2</sup> Ингэснээр Их Монгол улсын хил хязгаар Хорезм улстай шууд залгах болж, монголын цэрэг Хорезм руу довтлон орох үүдийг нээж өгчээ. Чингис хаан Хорезм улсыг байлдан эзэлж газар нутгаа тэлж, их хэмжээний олз ашиг олж авахыг гол зорилго болгосноос гадна бас Дундад Азийн нутгаар дамжин гарч байсан тухайн үеийн дорно, өрнийн худалдааны их замыг эзэмших давхар бодлоготой байсан билээ.

Аму-дарьяа мөрний адагт, Хятад ба Газрын дундад тэнгисийн хооронд, Энэтхэг ба Өмнөд Оросын харилцах замын уулзвар дээр оршиж байсан Хорезм улс бол тэр цагийн өндөр соёлтой улс байжээ. Хорезм улс дорно өрнө, улмаар өмнө зүгийн худалдааны төв болж тэр үеийнхээ олон улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байлаа. Монголын цэрэг Хорезм улсыг довтлох үед Хорезм нь Бухар, Перс, Афганистаны нутаг дэвсгэрийг хамарсан том гүрэн байлаа.<sup>3</sup> 1219 оны туулай жил Чингис хаан өөрийн биеэр цэрэг авч Хорезм улсын эсрэг байлдахаар шийджээ. Энэ талаар Монголын нууц товчоонд бичихдээ, “Туулай жил, Чингис хаан хатадаас Хулан хатныг авч, дүү нараас Отчигин ноёныг эх ордондоо үлдээгээд Арайн даваагаар давж,

\*Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Сартаул улстай байлдахаар морилов” гэжээ.<sup>4</sup> Харин байлдах болсон шалтгаан нь Хорезм улсын Отрар хотын захирагч Иналчик Монголын худалдаа хийхээр очсон 450 хүнийг барьж алсан явдал болжээ.<sup>5</sup> Елюй Чуцай Чингис хааны шадар зөвлөгчөөр хаантай хамт Хорезм улсын эсрэг хийсэн аян дайнд явжээ. Тэрээр монголын цэрэг Хорезм руу явсан замын маршрутыг тэмдэглэн, замдаа үзэж харснаа “Өрнө этгээд зорчсон тэмдэглэл” зохиолдоо тодорхой дүрслэн бичжээ.<sup>6</sup> Монголын цэрэг нутгаасаа 1219 оны зургаан сард гарсан бөгөөд их цэрэг хөдлөхийн өмнө цэргийн түгийг тахижээ. Тахилгын ёслолыг үйлдэх яг тэр үед тэнгэр гэнэт харанхуйлан “гурван тохойн хэмжээний бороо цас”<sup>7</sup> холилдон орсон нь муу ёр хэмээн Чингис хааны сэтгэл санааг нэлээд их зовоожээ. Тэгэхэд Елюй Чуцай “идэр зуны цагт бороо цастай цуг орох нь дайсан этгээдийг ялан дийлэхийн бэлэг тэмдэг” хэмээжээ.<sup>8</sup> Елюй Чуцайн энэхүү тайлал нь шинжлэх ухааны ямар ч үндэслэлгүй боловч бэлэг дэмбэрэлтэй тэрхүү үг нь тухайн үед монголын цэрэгт байлдах урам зориг оруулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн учраас Чингис хаанд нэн таалагдаж, түүний сэтгэлийг нь ч засжээ.

Чингис хаан цэргийнхээ хамт 1219 оны зун Алтайн уулсыг давж, Эрчис мөрөн хүрч хороолон буугаад зуны бүгчим халуун цагийг тэнд өнгөрүүлж, цэрэг морио амраан, зохион байгуулалт, арын албаны хангамж зэргийг шалган цэгцэлжээ. Бас цэцдийн зөвлөлийн хурал хийж Хорезм улсыг хэрхэн эзлэх, ямар замаар явах, хэдэн чиглэлээр дайтах байлдааны тактикийг хэлэлцэн тогтжээ. Елюй Чуцай Алтайн уулсыг даван, Эрчис мөрөн хүрэх замдаа ажигласан зүйлээ, ялангуяа Алтайн уулсын байгалийн үзэсгэлэнт сайхан байдлыг дүрслэн тодорхой бичжээ.<sup>9</sup> Чингис хааны цэрэг Эрчис мөрнөөс урагшаа уруудан Була хэмээх эртний хотод<sup>10</sup> ирээд тэндээс бас дахин урагшаа явж Борохоро нурууг давжээ.<sup>11</sup> Елюй Чуцай Борохоро уулсын үзэсгэлэнт байгалийг “Өрнө этгээд зорчсон тэмдэглэл” зохиолдоо дүрслэн нэлээд тодорхой бичихдээ, “зүүнээс баруун тийш нэг мянган ли /1 ли нь 0.5 км/, хойноос өмнө тийш хоёр зуун ли үргэлжилсэн уулын орой дээр нэгэн дугуй хэлбэрт цөөрөм буй бөгөөд түүний эргийн урт нь 70-80 ли орчим. Цөөрмийн урд нарны гэрэл ч үл нэвтрэх битүү алимны модон ойтой” хэмээжээ.<sup>12</sup> Дээр дурдсан цөөрмийг Елюй Чуцай мөн Тольт нуур гэж зохиолдоо тэмдэглэсэн нь өнөөгийн Сайрам нуурыг хэлж буй бололтой. Борохоро нурууг давсан монголын цэрэг 1211 оноос Их Монгол улсын мэдэлд орсон Алмалык<sup>13</sup> хотод хүрэлцэн иржээ. Елюй Чуцай зохиолдоо, энэ хотод янз бүрийн жимс элбэг, уг хотын 8-9 дагуул суурин

газарт усан үзэм, лийрийн мод ургуулан таван төрлийн буудай тариалдаг хэмээн тэмдэглэжээ.<sup>14</sup>

Тэнд хэсэг буудалласны дараа Чингис хааны цэрэг Или голыг гатлан Хар хятаны Баруун Ляо улсын нийслэл байсан Хосун орда,<sup>15</sup> Тараз<sup>16</sup> зэрэг хотуудаар дамжин явж 1219 оны есөн сард Отрар хотыг бүсэлжээ. Отрар хот нь Хорезм улсын гадаад худалдаа, олон улсын харилцааны зангилаа байв. Иймээс тус хот нь их бэхлэлт, харуул хамгаалалттай бас олон тооны цэрэгтэй байжээ. Отрар хотын захирагч Иналчик хийсэн хэрэгтээ ямар ч нөхцөл байдалд амьд гарахгүйгээ мэдэж байсанаас нүүрлэн ирсэн монголын цэрэгтэй үхэх сэхэхээ үзэхээр шийдэж цэрэг, иргэдээ дайчлан хотыг хамгаалж, монголын цэрэгтэй бүтэн таван сар тулалдан байлдсан ч арга буюу хүчин дутагдаж ялагджээ.<sup>17</sup>

Чингис хаан, отгон хөвгүүн Тулуйн хамт цэргийн гол хүчийг авч Сыр-дарьяа голыг гатлан Бухар хотыг дайлахаар явжээ. Тухайн үед Бухар хот бол Дундад Азийн худалдааны нэртэй том хотуудын нэг, мөн лалын шашинтны мөргөлийн төв байсан билээ. 1220 оны хоёр сард Чингис хааны цэрэг Бухарыг бүслэн дайрахад уг хотыг 20 мянган цэрэг хамгаалж байлаа.<sup>18</sup> Монголын цэрэг Бухар хотыг дөрвөн талаас нь бүслэн хороолж, олон зүгээс ширүүн довтолжээ. Бухар хотын захирагчид айн эмээснээс болж хотыг орхиж, амь зулбан зугадсан боловч монголын цэрэг хойноос нь нэхэн бут цохисон ажээ. Харин хотод үлдэж хоцорсон сүм хийдийн том лам нар, баячууд монголын цэрэгт бууж өгчээ.<sup>19</sup>

Бухарыг эзэлсэний дараа Чингис хаан Самарканд хотыг эзлэхээр давшиж, тэр үед Самаркандыг 110 мянган цэрэг хамгаалж байсан боловч ширүүн тулалдааны эцэст монголын цэрэгт эзлэгджээ.<sup>20</sup> Энэ тулалдаанд маш олон цэрэг, ард иргэд амь үрэгдсэн тухай Хятад газраас Чингис хааны зарлиг ёсоор уулзахаар Самарканд хотод хүрэлцэн ирсэн Чанчунь бомбын тэмдэглэлд “Самарканд хотод амьд үлдсэн хүн ам түрүүчийн бүх хүн амын дөрөвний нэг хувь байсан”, Чингис хааны шадар зөвлөгч Елюй Чуцайн зохиолд “хотын газар талбайн тэн хагасыг булш бунхангаар дүүргэв” хэмээн тус тус тэмдэглэн бичжээ.<sup>21</sup>

1220 оны хавар Самаркандыг эзэлсэний дараа Чингис хаан цэргийн хамт тэнд хэсэг хугацаагаар байрлаад мөн оны зуны сүүлч намрын эхээр Нахшеб /одоогийн Карши хот/ хотын ойролцоох тал нутагт очиж байрлан Хорезм улсын бусад хот сууринг эзлэх байлдааны

бэлтгэл хийж байлаа.<sup>22</sup> Харин Елюй Чуцай хааны зарлигаар Самаркандад үлдэж тус хотын захирагчаар томилогдсон Елюй Ахайн туслах болжээ.<sup>23</sup> Елюй Чуцай “Номхон даяанчийн зохиолын эмхтгэл”, “Өрнө этгээд зорчсон тэмдэглэл” зэрэг зохиолдоо, Самарканд гэдэг үг бол тэр нутгийн хэлээр “баян чинээлэг” гэсэн утгатай хэмээн тайлбарласан байдаг.<sup>24</sup> 1220-1222 онд Елюй Чуцай Самаркандад ажиллаж амьдрахын зэрэгцээ тэр нутгийн зан заншил, аж ахуй, ахуй амьдрал, байгалийн нөөц баялаг, цаг агаарын онцлог зэргийг ажиглан судалж байлаа. Тэр бүхнээ “Өрнө этгээд зорчсон тэмдэглэл” зохиолдоо тодорхой тэмдэглэн бичжээ. Тэрээр бичихдээ, “Самарканд бол баян чинээлэг газар. Гүйлгээнд гулдмай алт, гуулин зоос хэрэглэдэг байлаа. Хотыг тойрсон хэдэн арван ли үргэлжилсэн талбай бүхий жимсний цэцэрлэгтэй. Айл өрх бүр хувийн жимсний цэцэрлэгтэй, цэцэрлэг болгонд усжуулах системтэй, тоор чавганы модноос гадна улиас бургас зэрэг мод ургуулсан байлаа. Хулуу тарвас нь адуун толгойн чинээ том, шар будаа, шош буурцагаас бусад бүх төрлийн тариа тариалдаг. Ид зуны цагт хур бороо ордоггүй болохоор голын усаар тариалангийн талбайг усалдаг. Усан үзмээр нэн сайхан амттай дарс хийдэг байсан. Нутгийнхан цагаан өнгийг эрхэмлэн, хар өнгийг гашуудлын өнгө гэж үздэг учир бүгдээрээ цагаан хувцас өмсдөг байв” хэмээн дурджээ.<sup>25</sup>

Елюй Чуцай Самаркандад байхдаа хятад хуанлийг тухайн нутгийн хуанлитай харьцуулан “Баруун зүгийг номхотгох цагаан морин жилийн анхдагч хуанли”-г зохиож, 1222 онд Чингис хаанд өргөн барьжээ.<sup>26</sup> Елюй Чуцай Самаркандад байх хугацаандаа чөлөөт цаг харьцангуй ихтэй байсан тул анд нөхдийн хамт хөдөө нутгаар явж, тэр нутгийн байгалийн үзэсгэлэнт байдлыг сонирхон, үзэж харсан зүйлүүдээ “Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл” зохиолдоо тэмдэглэн үлдээжээ.<sup>27</sup> Елюй Чуцай Самаркандаас холгүй орших Бухарт их очдог байсан болохоор Чингис хааны зарлигаар томилогдсон Бухарын захирагч зүрчид гаралтай Пуца Чижинтэй нэлээд дотно харилцаа тогтоожээ. Тэрээр Бухар хотын онцлог бүхий соёл урлаг, дуу бүжиг, үзэсгэлэнт байгалийг яруу найргийн хэлбэрээр илэрхийлэн магтан бичиж, бичсэн зүйлээ анд Пуца Чижинд тогтмол илгээн уншуулдаг байлаа.<sup>28</sup>

1222 оны намар нутаг буцахаар Чингис хаан цэргээ авч Амударья мөрнийг гатлан Самаркандад ирж өвөлжсөн билээ. Тэнд байхдаа Елюй Чуцайг Тараз хот /одоогийн Джамбул хот/ руу газар тариалангийн хэрэг эрхэлсэн даргаар томилон явуулж, атар газрыг

эзэмших үүрэг даалгавар өгчээ.<sup>29</sup> Чингис хаан 1224 оны зун Ирчис мөрөнд хүрэлцэн ирж, тэндээ нэлээд удаан хугацаагаар саатаж, агт морь, цэргээ амрааж алгуур явсаар 1225 оны хавар нутагтаа буцаж иржээ.<sup>30</sup> Елюй Чуцай Чингис хаантай цуг Монгол нутаг руу буцалгүй ажиллаж байгаад 1224 оны намар тэндээс Монгол руу буцахаар гарчээ. Елюй Чуцай замдаа Алмалык хотоор дамжин 1225 оны өвөл Бешбалиг /одоогийн СҮӨЗО-ны Джимсарын нутаг дэвсгэрт оршиж байсан эртний хот/ хотод хүрэлцэн иржээ.<sup>31</sup> Елюй Чуцай Бешбалигт ирээд төдий л удаагүй байтал Чингис хаан Тангудын Сися улсын эсрэг дайтахаар шийдвэрлэжээ. 1225 оны арваннэгэн сард Чингис хаан өөрийн биеэр 100 мянган цэрэг авч Тангудын Сися улсыг дайлахаар хөдөлсөн.<sup>32</sup> Үүнээс өмнө Монголын цэрэг Тангудын эсрэг 1205, 1207, 1209 онуудад нийт гурван удаа томоохон байлдааны ажиллагааг явуулсан билээ.<sup>33</sup> 1219 онд Чингис хаан Хорезмыг дайтахаар мордохдоо Тангудын Сися улсаас цэргээр туслахыг шаарджээ. Чингис хааны элч Тангудын эзэн хаанд зарагдан очиж, Чингис хааны өмнөөс ингэж хандан өгүүлсэн нь: “Баруун гар чинь больё гэж чи хэлсэн биш үү? Сартуул улсад алтан аргамжаа таслуулаад би хариу авахаар мордов. Баруун гар болж морил!”<sup>34</sup> гэж шаардахад Тангудын хааны шадар сайд Аша Хамбу<sup>35</sup> хэлсэн нь: “хүч хүрэхгүй бол хаан юунд болов”<sup>36</sup> хэмээн Чингис хааны тавьсан шаардлагаас татгалзан элчийг буцаажээ. Дээрхи явдал Чингис хааны сэтгэлд үл нийцэн, “Аша Хамбуд яаж ингэж хэлэгдэх билээ? Урьдаар тэдэнтэй очиж байлдвал зохилтой биш үү? Гэвч өөр хүнд зорьж байгаа цаг тул энэ удаа больё. Мөнх тэнгэрт ивээгдэж алтан жолоогоо бататгаж ирвэл, тэр цагт магад болтугай” хэмээн өрнөдөд аян дайн хийсний дараа эргээд тангудтай тооцоо хийж, эцсээ хүртэл тулалдах зорилт тавьжээ.<sup>37</sup> Тангудын эсрэг байлдахаас өмнө Чингис хаан элчийг томилон Тангудын хаанд дайн зарласан тухай бичиг явуулжээ. Уг бичигт дурдахдаа, “Урьд тангад иргэн баруун гар болж тусалъя! гэж Бурхан /Тангудын эзэн хаан/ чи хэлсэн билээ. Чиний тэр үг ёсоор бид сартуул иргэнийг эрхэндээ оруулахаар мордохдоо чамд мэдэгдвэл, Бурхан чи хэлсэн үгэндээ хүрсэнгүй, цэрэг ч өгсөнгүй, харин их үгээр дайрсан билээ. Тэр үед бид өөр улсад зорьсон тул дараа учраа ололцъё гэж сартуул иргэнд морилж, мөнх тэнгэрт ивээгдэж, сартуул иргэнийг эрхэндээ оруулж, одоо Бурхан чамтай учраа ололцъё гэж ирэв” гэжээ.<sup>38</sup> Дээр дурдсан шалтгаан болон Тангудын хаан хөвгүүнээ Их Монгол улсад барьцаа болгон ирүүлээгүй, мөн Чингис хааны дайсан Чилахэянкунийг<sup>39</sup> хүлээн

авч орогнуулсан зэрэг шалтгаанаар Монголын цэрэг тангудтай байлдах болсон тухай түүхийн сурвалж бичигт заажээ.<sup>40</sup> Чингис хаан биеэр их цэрэг авч Тангудыг дайлаар мордохдоо хөвгүүдээс Өгэдэй, Тулуй, жанжин нараас Сүбээдэй, зөвлөх нараас Буурч, эрдэмтдээс Елюй Чуцайг авч явжээ. Дээр дурдсан хүмүүс бол Чингис хааны “Сэцэдийн зөвлөл”-ийн гол гишүүд байлаа.<sup>41</sup>

Елюй Чуцай Чингис хааны их цэрэгтэй хамт Тангудын Сися улсын нутаг дэвсгэрт орж ирээд 1226 ны таван сарын үед Сучжоу хотын харьяа Шаньшань хэмээх суурин газарт /одоогийн Ганьсу мужийн Цзюйцюань хот/ байралжээ.<sup>42</sup> 1226 оны намар монголын цэрэг Ганчжоу, Шилиян зэрэг хотуудыг эзэлсний дараа, мөн оны өвөл Тангудын томоохон хот болох Линчжоу /одоогийн Нинся хотонгийн өөртөө засах орны Линьву хотын баруун өмнө талд оршиж байсан эртний хот/-г эзэлж, “цэргийн жанжин нар хөвгүүд охид, хөрөнгө зоосыг булаацалдан авч байсан бол Елюй Чуцай гүн ердөө л хэдэн боть ном судар, хоёр тэмээ ачаатай тэнцэх хэмжээний гишүүнэ авчээ. Хожим цэргүүдийн дунд өвчин тархаж, зөвхөн тэр гишүүнэ л хэрэг болж хэдэн түмэн хүний амийг аврав” хэмээн ном, сурвалжид тэмдэглэжээ.<sup>43</sup> Линчжоу хотыг эзэлсний дараа монголын цэрэг Тангудын нийслэл Чжунсинфу-г /одоогийн Нинся хотонгийн өөртөө засах орны төв Иньчуан хот/ 1227 оны долоон сард эзэлснээр Тангудын Сися улс мөхжээ.<sup>44</sup> Елюй Чуцай монголын их цэрэгтэй хамт 1227 оны есөн сард Монгол нутагт буцаж иржээ.<sup>45</sup>

Елюй Чуцай Чингис хааны баруун зүгийн буюу Дундад Азийн орнуудыг байлдан дагуулах аян дайнд дагалдан явахад түүний эрх үүрэг төдий л их биш, тэрээр хэдийгээр Чингис хааны дэргэд алба хааж байсан боловч хаан түүнийг чухал албан тушаалд тавьж ажиллуулаагүй, зөвхөн бичиг баримтын төсөл боловсруулах болон байгалийн үзэгдэл, тухайлбал, зуны цагт цас орох, өвлийн цагт тэнгэр дугарах, мөн нар, сар хиртэх зэрэг байгалийн үзэгдлийн учир шалтгааныг тайлбарлахад л ашиглаж байлаа.<sup>46</sup> Елюй Чуцай Дундад Азид алба хашиж байсан 10 орчим жилийн хугацаандаа хамгийн өндөр албан тушаалд томилогдсон нь 1222 онд Тараз хотын газар тариалангийн хэрэг эрхэлсэн даргаар томилогдсон /энэхүү албан тушаалд томилогдохоос өмнө Елюй Чуцай 1220-1222 онд Самарканд хотын захирагчийн туслах байсан/ явдал байлаа.<sup>47</sup> Чингис хаан заримдаа Елюй Чуцайгаар мэргэ төлгө үйлдүүлж байсан тухай түүхэнд тэмдэглэсэн байдаг.<sup>48</sup> Чингис хаан дайн байлдаанд мордохынхоо өмнө

заавал мэргэлүүлдэг байсан бөгөөд бусдаар мэргэлүүлсэнийг өөрийнхөө мэргэлсэнтэй тохирч буй эсэхийг шалгадаг зуршилтай байлаа.<sup>49</sup>

Чингис хаан Елюй Чуцайг өндөр албан тушаалд тавьж ажиллуулаагүй байсан шалтгаан нь дор дурдсан зүйлтэй холбоотой байсан болов уу. Дундад Азийн орнуудын байгалийн нөхцөл, үйлдвэрлэлийн харилцаа, ард иргэдийн ухамсар, дадал заншил зэрэг нь цөм Елюй Чуцайн төрж өссөн газар нутгийнхаас тэс өөр байсан учраас тэдгээр орныг Елюй Чуцайн баримталж байсан “Күнзийн сургаалаар улс орныг ноёрхон захирах” онол, арга замаар үнэхээр захирч болохгүй байсан билээ. Ийм ч учраас Елюй Чуцайн “Күнзийн сургаалаар улс орныг ноёрхон захирах” талаар тавьсан удаа дараагийн санал зөвлөгөөг Чингис хаан хүлээж авсангүй. Энэ талаар Елюй Чуцай “Номхон даяанчийн зохиолын эмхтгэл” зохиолдоо нэг бус удаа дурдан бичжээ.<sup>50</sup> Чингис хааны дэргэд 10 орчим жил алба хаахдаа /1218-1227/ эрх үүрэг нь төдий л их биш байсанд Елюй Чуцайн сэтгэл хангалуун бус байснаа ном зохиолдоо олон удаа илэрхийлжээ.<sup>51</sup> Гэвч чухал албанд тавиагүй хэмээн Елюй Чуцай сэтгэл санаагаар унаж гутарсангүй, харин ч түүний эрдэм мэдлэг, мэргэн ухааныг үнэлэн хэзээ нэгэн цагт улс орныг удирдан захирах төрийн том байгууллагад ажиллуулна гэж ямагт итгэж байсан бодол санаагаа илэрхийлсэн шүлгүүд “Номхон даяанчийн зохиолын эмхтгэл”-д цөөнгүй байсан билээ.<sup>52</sup>

Чингис хаан хэдийгээр Елюй Чуцайг тухайн үед өндөр албанд тавьж ажиллуулаагүй боловч Дундад Азийн орнуудыг байлдан дагуулах аян дайнд олон жил хамт явсан учир их мэдлэг боловсролтой хүн болохыг сайн мэдэж, тохиромжтой цагт түүнийг өндөр албанд дэвшүүлэн ажиллуулах хэрэгтэй гэж бодож байлаа. Иймээс ч Чингис хаан, хөвгүүн Өгэдэйд захиж хэлэхдээ, “Энэ хүнийг тэнгэр бурхан бидэнд илгээсэн юм шүү. Хойшид түүнийг төр болон цэргийн хэрэгт оролцуулах ёстой” хэмээжээ.<sup>53</sup> Дээр дурдсан зүйл нь Өгэдэй хааны үед Елюй Чуцай Их Монгол улсын төрд өндөр тушаалын алба хашихад чухал үүрэг гүйцэтгэж, түүний амьдралд эргэлт гарахад зохих нөлөө үзүүлжээ.

### ТАЙЛБАР, ЗҮҮЛТ

1. Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр. Елюй Чуцай нь 1190-1224 оны хооронд амьдарч байсан. Тэрээр Чингис, Өгэдэй хаадын дэргэд 30 шахам жил Их Монгол улсын төрд алба хашиж байжээ.
2. Татаро-монголы в Азии и Европе. Сборник статей. Москва, 1970, стр. 87-88., Хятадын түүхийн их толь бичиг /Чжунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 144 дэх тал.
3. Монголын нэвтэрхий толь, 2-р боть, УБ., 2000, 1013 дахь тал., Советский энциклопедический словарь, Москва, 1985, стр. 1452.
4. Монголын нууц товчоо /хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав/, УБ., 1957, 228 дахь тал.
5. Рашид-ад-Дин. Сборник летописей, т.1, кн.2, М-Л, 1952, стр. 189., Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
6. Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
7. Юан улсын судар, 146-р дэвтэр.
8. Мөн тэнд
9. Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
10. Була хот нь өнөөгийн СУӨЗО-ны Эби нуурын баруун талд орших Бор хотууны нутаг дэвсгэр дээр оршиж байсан бөгөөд тухайн үед дорно өрнийн харилцааны чухал зангилаа газар байлаа.
11. Борохоро нуруу нь Тэнгэр уулсын нэг нуруу бөгөөд 250 км урт, 4359 метр өндөр, олон мөсөн голтой, уулт хээр, гацууран ой, нугатай.
12. Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
13. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, УБ., 1995, 131 дэх тал., Рашид-ад-Дин. Сборник летописей, т.1, кн.2, М-Л, 1952, стр. 182, 198., Хятадын түүхийн их толь бичиг /Чжунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 260 дахь тал.
14. Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
15. Рашид-ад-Дин. Сборник летописей, т.1, кн.2, М-Л, 1952, стр. 67, 182.
16. мөн ном, стр. 140, 182.



17. Д. Майдар. Чингис хаан ба Монголын их гүрэн, УБ., 1990, 62 дахь тал.
18. The History of the world-conqueror by Ala-al-Din'Ata-Malik Juvani, translation from the text of M.M.Qazvini by J.A.Boyle, Manchester University press, 1958, v.1, p.103; Рашид-ад-Дин. Сборник летописей, т.1, кн.2, М-Л, 1952, стр. 205.
19. Рашид-ад-Дин. Сборник летописей, т.1, кн.2, М-Л, 1952, стр. 205.
20. мөн ном, стр. 207-209.
21. Ли Чжичан. Чанчунь бумбын баруун газар зорчсон тэмдэглэл /Чанчунь чжэньжэнь сиюйцзи/. Ли Чжичан нь 1193-1256 оны хооронд амьдарч байсан. Чанчунь бомбын итгэлт шавь байсан бөгөөд Чанчунь бомбо Чингис хаантай уулзахад тэрээр ямагт дэргэд нь байжээ., Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 6-р дэвтэр.
22. Рашид-ад-Дин. Сборник летописей т.1, кн.2, М-Л, 1952, стр.214-216.
23. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын этхтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 12-р дэвтэр., Хятадын түүхийн их толь бичиг /Чжунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 296 дахь тал. Елюй Ахай-хятан угсааны хүн бөгөөд Чингис хааны шадар сайдуудын нэг, Тангудын Сися улстай байлдахад цэргийн их гавьяа байгуулсаныг өндрөөр үнэлэн түүнийг 1214 онд хааны зарилгаар “тайш” хэмээх албан тушаалд дэвшүүлэн ажиллуулжээ.
24. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын этхтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 12-р дэвтэр., Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
25. Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр.
26. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын этхтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 8-р дэвтэр., In the Service of the khan, Edited by Igor de Rachewiltz, Hok-lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W.Geier, Harrassowitz Verlag.Wiesbaden, 1993, p. 146-147.
27. Мөн ном, 2,5,6-р дэвтэр.
28. Мөн ном, 5-р дэвтэр.
29. Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр.
30. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966, 238 дахь тал., Рашид-ад-Дин. Сборник летописей т.1, кн.2, М-Л, 1952, стр. 226.

31. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын этхтгэл /Чжанжан цзюйши вэньци/, 8-р дэвтэр., Рашид-ад-Дин. Сборник летописей т.1, кн.,М-Л, 1952, стр. 148-149.
32. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966, 239 дэх тал., Татаро-монголы в Азии и Европе. Сборник статей. Москва, 1970, стр. 54., Монголын нэвтэрхий толь, 2-р боть, УБ., 2000, 830 дахь тал.
33. Татаро-монголы в Азии и Европе. Сборник статей. Москва, 1970, стр. 47-49.
34. Монголын нууц товчоо. УБ., 1957, 228 дахь тал.
35. Аша-Хамбу нь Тангудын Сися улсын эзэн хааны ихээхэн эрх мэдэл бүхий төрийн түшмэл байжээ. Тэрээр зарим үед хааны нэрээр зарлиг шийдвэр дураар гагадаг байлаа. Түүний тухай Монголын нууц товчооноос өөр сударт нэг их дурьдаггүй юм. Ч.Далай. Монголын түүх, Их Монгол улс /1206-1260/ дэд дэвтэр, УБ., 1994, 126 дахь талыг үз., Хамба-төвд үг. Шашны ёсны сүм хийдийн хэргийг тэргүүлэн удирдах хүний тушаал, О. Сүхбаатар. Монгол хэлний харь үгийн толь. УБ., 1999, 225 дахь талыг үз.
36. Монголын нууц товчоо. УБ., 1957, 228 дахь тал.
37. Мөн гэнд
38. Козин С.А. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г. Юань-чао-би-ши, М-Л.,1941, стр. 190., Монголын нууц товчоо. УБ., 1957, 236 дахь тал.
39. Чилахэянькун бол Хэрэйд аймгийн Ван хангийн хөвгүүн. Арванхоёрдугаар зууны сүүлчээр Хэрэйд аймгийн хан нь Тоорил гэгч байлаа. Тоорил ханд 1196 онд Алтан улсаас ван цол өргөмжилснөөс хойш Ван хан гэж нэрлэгдэх болж, түүхэнд ч энэ нэрээр бичигджээ. Чингис хааны тухай товч тайлбар толь, УБ., 1992, 33-35 дахь тал., Хятадын түүхийн их толь бичиг /Чжунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 144 дэх талыг үз.
40. Юан улсын судар, 1-р дэвтэр.
41. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966, 239 дэх тал., Ч.Далай. Монголын түүх, Их Монгол улс /1206-1260/ дэд дэвтэр, УБ., 1994, 110 дахь тал.
42. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхтгэл /Чжанжан цзюйши вэньци/, 13-р дэвтэр.
43. In the Service of the khan, Edited by Igor de Rachewiltz, Hok-lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W.Geier, Harrassowitz Verlag,Wiesbaden, 1993, p. 146-147. Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Г очао вэньлэй/, 57-р дэвтэр. Су Тяньцзюе

- нь 1294-1325 оны хооронд амьдарч байсан. Тэрээр Юан улсын төрд алба хашиж байгаад Тогоонтөмөр хааны үед 1352 онд Улаан алчууртны бослогыг дарахад дайчлагдаж, дайн байлдааны явцад өвчнөөр нас барсан. Түүний эцэг Су Чжидао /1261-1320/ Их Монгол улсын төрд мөн алба хашиж байсан. А. Дамдинсүрэн. Монголын цэргийн товч түүх, УБ., 1990, 121 дэх тал.
44. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ, 1966, 239 дэх тал., Хятад улсын нэвтэрхий түүх /Чжунго тунши/, 6-р дэвтэр, Бээжин, 1997, 199 дэх тал.
45. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 3-р дэвтэр.
46. Юан улсын судар, 146-р дэвтэр., Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анри /Гочао вэньлэй/, 57-р дэвтэр., Сун Цзычжэнь. Төв бичгийн яамны сайд Елюй гүнгийн хөшөөний бичээс /Чжуншулин Елюй гүн шэньдао бэй/. Сун Цзычжэнь нь 1185-1266 оны хооронд амьдарч байсан. Тэрээр 1235-1265 оны хооронд Их Монгол улсын төрд алба хашиж байжээ. Н.Ц.Мункуев. Китайский источник о первых монгольских ханах, Москва, 1965, стр.15.
47. Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр.
48. Юан улсын судар, 146-р дэвтэр.
49. Мөн гэнд
50. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын этхтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 3, 11-р дэвтэр.
51. Мөн зохиол. 2,3-р дэвтэр.
52. Мөн зохиол. 3,4-р дэвтэр.
53. Юан улсын судар, 146-р дэвтэр.